



UNDEF



The United Nations
Democracy Fund

Глоб Интернэшнл төв

Суурь судалгааны тайлан

Төслийн нэр: Иргэдийн мэдээлэл авах эрхийг нэмэгдүүлж, Монголд ил тод
шударга байдлыг хөхиүлэн дэмжих нь

2013 он

Table of Contents

Оршил	4
Нэр томъёо, товчлол	5
Судалгааны хэрэгцээ, шаардлага.....	6
Судалгааны зорилго.....	6
Судалгааны зорилт.....	6
Судалгааны арга, шалгуур үзүүлэлтүүд	6
Судалгааны хамрах хүрээ.....	7
Судалгааны хугацаа	8
СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН.....	8
Хүснэгт 1 Судалгаанд оролцогчдын нас, боловсрол	8
Зураг 1 Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал.....	8
Зураг 2 Иргэдийн удирдлагаас гаргаж байгаа шийдвэр тогтоолыг сонирхох байдал.....	8
Зураг 3 Сонирхлын зөрчлийн тухай хууль хэнд их хамаатай гэж бодож байна вэ?	9
Зураг 4 Албан тушаалтны ашиг сонирхлын мэдүүлэг олон нийтэд нээлттэй байх ёстой юу ? ...	10
Зураг 5 АСЗ-ж байгаа тухайгаа мэдэгдэх ёстой юу ?	10
Зураг 6 АСЗ-ийн мэдүүлгээ хэд хоногийн дотор гаргаж өгөх ёстой вэ ?	10
Зураг 7 Сумын хөгжил хэнээс хамгийн их хамаарах вэ?	11
Нэг. Төрийн байгууллагаас мэдээлэл авч байсан туршлага ба мэдээлэл авсан байдал	11
Зураг 8 Танд төрийн албан хаагчид хэр сайн үйлчилсэн бэ?.....	12
Зураг 9 Яагаад танил тал хэрэгтэй вэ ?	12
Хүснэгт 2 Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд гарсан хүндрэл, бэрхшээл.....	13
Хоёр. Мэдээлэл авах эрхийн тухай ойлголт	14
Зураг 10 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэр сайн мэдэх вэ?	15
Зураг 11 Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн мэдлэг аймаг тус бүрээр.....	15
Зураг 12 Төрийн байгууллагаас дараах.....	16
мэдээллийг авах эрхтэй юу ?	16
Зураг 13 Төрийн байгууллагаас мэдээлэл авахтай холбоотой дараах зүйлсд санал нийлж байна уу	16
Хүснэгт 3 Төрийн байгууллагаас дараах мэдээллийг авах эрхтэй юу, мэдээлэл авахтай холбоотой зүйлсд санал нийлж байна уу.....	17
Гурав. Ил тод, шударга байдал	18

Зураг 14 Төрийн байгууллагын мэдээлэл яагаад ил тод байх ёстой вэ?	18
Зураг 15 Төрийн байгууллагын мэдээлийг ил тод болгосноор ямар ач холбогдолтой вэ?	19
Зураг 16 Танай сумын мэдээллийн самбарт дараах мэдээллүүд байдаг уу? Цаг тухай бүрт нь мэдээлдэг үү?.....	20
Зураг 17 Удирдах албан тушаалтнуудын үйл ажиллагаагаа тайлагнах байдал	21
Хүснэгт 4. Сумын засаг дарга, багийн засаг дарга нарын ажлаа тайлагнах байдал	21
Зураг 18 Суман дах байгууллагуудын үнэлэмж.....	22
Зураг 19 Үйлчилгээний шуурхай байдал.....	22
Хүснэгт 5 Багийн ИНХ, сумын ИТХ-ын тухай.....	23
Хүснэгт 6 Багийн ИНХ, сумын ИТХ-ын нээлттэй байдал, иргэдийн оролцоо	23
Зураг 20. Иргэдэд ойр төрийн албан хаагчид (хамгийн ойр байдгаас эхлүүлэн жагсаавал)	23
Дөрөв. Мэдээллийн эх сурвалж	24
Зураг 22 Төрөл бүрийн мэдээ, мэдээлэл авдаг ХМХ.....	25
Зураг 23 Орон нутгийнхаа тухай мэдээлэл авдаг ХМХ	26
Хүснэгт 7 Мэдээлэл түгээх хэрэгслийн хэрэглээ.....	26
Хүснэгт 8 Мэдээллийн ойлгогдох байдал	27
Хүснэгт 9 Иргэдийн хүсч буй мэдээллийн төрөл, мэдээлэл түгээх суваг тус бүрээр	27
Дүгнэлт.....	28
Зөвлөмж	32

Оршил

Энэхүү судалгааны тайлан нь Глоб Интернэшнл төвийн хэрэгжүүлж буй “Иргэдийн мэдээлэл авах эрхийг нэмэгдүүлж, Монголд ил тод байдал, шударга ёсыг хөхиүлэн дэмжих нь” төслийн хүрээнд хийгдсэн юм.

Судалгааг төсөл хэрэгжих 8 аймгийн 20 сумын иргэдийн мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, төрийн байгууллагын ил тод, шударга байдлын түвшин, түүнд нөлөлөлөх хүчин зүйлс зэрэг мэдээлэл түүнтэй холбогдох хууль эрх зүйн талаарх мэдлэг ойлголт, суман дах төрийн байгууллага, үйлчилгээний өнөөгийн байдлыг тодорхойлж, төслийн үйл ажиллагаанд хэрэгцээт мэдээлэл болон эцсийн үр дүнг үнэлэхийн тулд явуулсан болно.

Судалгааны гол үр дүнг төсөл хэрэгжих сумдын нийт иргэдийг төлөөлүүлж, 1948 түүвэрт үндэслэн гаргав.

Нэр томъёо, товчлол

Тайланд ашиглагдаж буй ойлголт, нэр томъёо нь “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” гэсэн хоёр хуулинд зааснаар тайлбарлагдана.

Ил тод байдал – Шийдвэр гаргах эрх мэдэл бүхий хүмүүс тайлагнах, шүүмжлэл сонсох, олон нийтийн санал хүсэлтийг хүлээн авч, түүний дагуу үйл ажиллагаагаа ардчилсан нээлттэй аргаар явуулах.

Шударга байдал –Төрийн байгууллага, төрийн албан хаагчид ил тод байж, хуулиар хүлээсэн үүргээ сайн биелүүлж, ёс зүйтэй ажиллах.

АСЗ	Ашиг сонирхлын зөрчил
ЖДБ	Жижиг дунд бизнес
МАА	Мал аж ахуй
МУ	Монгол Улс
МҮОНР	Монголын Үндэсний олон нийтийн радио
МҮОНТ	Монголын Үндэсний олон нийтийн телевиз
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ТАХ	Төрийн албан хаагч
ТББ	Төрийн бус байгууллага
ТВ	Телевиз
УИХ	Улсын их хурал
ХМХ	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл

Судалгааны хэрэгцээ, шаардлага

Хүний нийгмийн оршин тогтнох нэг гол үндэс нь мэдээлэл бөгөөд хүний амьдралын нэг хэрэгцээ нь аюулгүй байх хэрэгцээ юм. Тиймээс бид оршин тогтнож, амьдрахын тулд бидний төлөө хийж бүтээх, шийдэх, захиран зарцуулах эрхийг хэсэг хүмүүст өгдөг. Эдгээр төлөөлөл болсон хүмүүс сайн засаглалыг бий болгох үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлж, сайн засаглалыг цогцлоож чадаж байна уу үгүй юу гэдгийн нэг чухал шалгуур үзүүлэлт нь иргэд мэдээлэлтэй байна уу, үгүй гэсэн асуулт юм.

Тиймээс Монгол Улсын Үндсэн хуульд **Бүх төрийн үйлчилгээ хуулийн дагуу иргэдэд ил тод байж, төр түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй** хэмээн заасан байдаг.

Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдэлж, сайн засаглалыг цогцлоохын тулд “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль 2011 оны 6-р сард батлагдсан. Хууль батлагдсантай холбогдуулан иргэд төрийн болон төрийн бус байгууллага ялангуяа иргэдийн дунд мэдээллийн ил тод байдал гэж юу болохыг таниулах, төрийн байгууллага, үйлчилгээний ил тод, шударга байдлыг хянах чадвар бий болгох хэрэгтэй. Үүний тулд одоо ажиллаж байгаа төрийн албан хаагчид, иргэд дээрх хуулийн талаарх ойлголт, төрийн байгууллагын ил тод, шударга байдал ямар түвшинд байгаа, түүнд юу нөлөөлөж байгааг тандах шаардлагатай байна.

Энэхүү судалгааны дүн мэдээ нь төслийн багийнханд төсөл хэрэгжих 8 аймгийн 20 сумын орон нутгийн засаг захиргааны ил тод, шударга байдал, иргэдийн ил тод, шударга байдал, мэдээлэл авах эрхийн тухай мэдлэг, ойлголтын тухай ерөнхий төсөөлөлтэй болно. Улмаар “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах, үр дүнтэй хэрэгжихэд чухал шаардлагатай мэдээлэл бүхий баримт бичиг болж, төслийн үр дүнг үнэлэхэд ашиглагдах юм.

Судалгааны зорилго

Мэдээлэл авах эрхийн тухай иргэд, төрийн албан хаагчдын мэдлэг ойлголт, төрийн байгууллагын ил тод, шударга байдлын түвшинг тогтоон, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлс, мэдээлэл авах суваг, боломж, хэрэгцээтэй мэдээллийн төрлийг илрүүлэх нь энэхүү судалгааны гол зорилго болно.

Судалгааны зорилт

- Мэдээлэл авах эрхийн тухай иргэд, төрийн албан хаагчдын мэдлэг ойлголтыг тогтоох
- Төрийн мэдээлэл авч байсан арга барил, туршлагын зураглал гаргах
- Төрийн байгууллагын ил тод, шударга байдлын түвшинг тодорхойлох
- Төрийн байгууллага, үйлчилгээний ил тод, шударга байдалд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг илрүүлэх
- Мэдээлэл хүлээн авч байгаа суваг арга хэлбэрийг тодорхойлж, мэдээлэл авах боломж, хүсэлтийг илрүүлэх

Судалгааны арга, шалгуур үзүүлэлтүүд

Төсөл хэрэгжих 8 аймгийн 20 сумын иргэдийн дунд урьдаас бэлтгэн боловсруулсан анкетаар судалгаа авч иргэдийн мэдлэг ойлголтын түвшин, төрийн байгууллагын ил тод шударга байдал

өгөх үнэлгээг хэмжинэ. Мөн тус сумдын төрийн албан хаагчидтай ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийсэн.

Энэхүү судалгааны шалгуур үзүүлэлт нь дараах хэдэн дэд үзүүлэлтүүд болно.

	Дэд шалгуур үзүүлэлтүүд	Баримтлах үндсэн зарчим
1	Төрийн байгууллагаас мэдээлэл авч байсан арга барил, туршлага	Бодит жишээ баримт, тоон мэдээлэл цуглуулах,
2	Мэдээлэл авах эрхийн тухай иргэдийн мэдлэг, ойлголт	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн заалтууд
3	Төрийн албан хаагчийн иргэдэд үйлчлэх байдал, тэдгээрийн үүрэг	Төрийн байгууллагын мэдээлэл иргэдэд ил тод, нээлттэй байна уу?, төрийн байгууллага, төрийн албан хаагчид иргэдэд үйлчлэх үүргээ хэрхэн биелүүлж байна вэ?
4	Мэдээлэл хүлээн авч байгаа суваг, арга хэлбэрийг тодорхойлох	Сумдад мэдээлэл түгээх байдал, иргэдийн мэдээлэл авах боломж, хүсэлт

Дээрх дэд шалгуур үзүүлэлтийг хангах асуултуудыг боловсруулахдаа “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийн заалт дээр суурилж, найдвартай, хэмжигдэхүйц байх зарчмыг баримталсан юм.

Ил тод, шударга байдлын түвшинг үнэлэх аргачлал

Ил тод байдалд	Шударга байдал
Удирдах албан тушаалтны тайлагнах байдал	Төрийн байгууллагын ил тод байдал
Баг, сумын хурал иргэдэд нээлттэй эсэх	Захиргааны мэдээллийн самбар дээрх мэдээлэл
Баг, сумын хурал шийдвэр гаргахдаа иргэдийн саналыг авч, шүүмж сонсох байдал	Үйл ажиллагаа сайн, иргэдтэй соёлтой харицаж хууль, дүрэм, журам, иргэдэд үйлчлэх ёстой гэдгээ мэдэж байгаа эсэх

Судалгааны хамрах хүрээ

Судалгааг төсөл хэрэгжих найман аймгийн 20 сумын иргэдээс авсан. Анкетын аргаар тухайн сумын насанд хүрсэн (18+) иргэдийн тоонд тулгуурлан түүвэрлэлт хийж авав. Нийт түүврийн хэмжээ 2000 байхаас 1948 анкетыг сонгон авч үр дүнг гаргасан.

Аймаг	Тоо	Сум	Тоо	Аймаг	Тоо	Сум	Тоо
Сүхбаатар	257	Мөнххаан	89	Баян-Өлгий	412	Буянт	57
		Асгат	50			Толбо	83
		Наран	37			Улаанхус	173
		Сүхбаатар	81			Баяннуур	99
Өвөрхангай	470	Хужирт	161	Увс	174	Зүүнговь	52
		Хархорин	309			Тэс	122
Булган	127	Бугат	51	Хөвсгөл	272	Цагааннуур	41
		Орхон	76			Улаан-Уул	105
Архангай	164	Өлзийт	79			Цагаан-Уул	126
		Батцэнгэл	88	Нийт	1948	Нийт	1948
Ховд	69	Алтай	69				

Судалгааг төслийн багийн гишүүд удирдан тухайн суманд ажиллах томилолтын хугацаанд багтааж, сумын багш нараас сонгон, анкеттай танилцуулан хэрхэн авах талаар зааж, иргэдээс судалгааг авлаа. Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлаганд төрийн албан хаагчид хамрагдсан болно.

Судалгааны хугацаа

Судалгааны мэдээлэл цуглуулалт 2013 оны 1-р сарын 18-ны өдрөөс 3-р сарын 17-ны өдрийг хүртэл үргэлжилж, шивэлт, хяналт шалгалт, боловсруулалтыг нийт 4 сарын хугацаанд хийж гүйцэтгэв.

СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

Судалгаанд оролцогчдын 55 хувь нь эмэгтэй, 45 хувь нь эрэгтэй, 74 хувь нь 18-45 насных, 75 хувь нь бүрэн дунд түүнээс дээш боловсролтой иргэд байна. (Хүснэгт 1.)

Хүснэгт 1 Судалгаанд оролцогчдын нас, боловсрол

Нас		Боловсрол	
18-25 нас	16.50%	Дээд /Магистр болон түүнээс дээш/	1.70%
26-35 нас	28.40%	Дээд /Бакалавр/	23.10%
36-45 нас	29.30%	Тусгай дунд	12.40%
46-55 нас	16.50%	Бүрэн дунд	33%
56-аас дээш	9.30%	Бүрэн бус дунд	15.60%
Нийт	100%	Бага боловсролтой	5.60%
		Боловсролгүй	2.30%
		Хариулаагүй	6.30%
		Нийт	100%


Ажил эрхлэлтийн хувьд 56 хувь нь МАА, газар тариалан, төрийн болон хувийн хэвшилд ажил хөдөлмөр эрхэлж байна. (Зураг 1.)

Зураг 1 Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал



Оролцогчдын 39 хувь нь засгийн газрын шийдвэр тогтоолыг, 50 хувь нь засаг даргын шийдвэр тогтоолыг “Маш их”, “Их” сонирхож байна. Аль ч шийдвэр тогтоолыг “Огт сонирхдоггүй” иргэд яагаад гэвэл “мэдээлэл байдаггүй, надад хамаагүй, төрд, удирдлагад итгэл алдарсан болохоор” гэсэн шалтгаан хэлж байна. (Зураг 2.)


Зураг 2 Иргэдийн удирдлагаас гаргаж байгаа шийдвэр тогтоолыг сонирхох байдал



“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийг 6 хувь нь “Сайн мэднэ”, 27 хувь нь “Ерөнхийд нь мэднэ”, 48 хувь нь “Тийм хууль байдаг гэж сонсож байсан, гэхдээ сайн мэдэхгүй”, 18 хувь нь “Огт сонсож байгаагүй” гэж хариулсан байна. Тэр дундаа төрийн болон төсвийн байгууллагад ажилладаг иргэдийн 6 хувь нь энэ хуулийн талаар сайн мэднэ гэсэн бол 14 хувь нь “Огт мэдэхгүй” гэсэн хариулт анхаарал татаж байна.


Сайн мэднэ, ерөнхийд нь Мэднэ гэж хариулсан 645 (33%) (Цаашид МЭДНЭ) иргэн дээрх хуулийг сумын засаг дарга, тамгын газрын дарга, сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт илүү их хамааруулан ойлгож, дунджаар 13 хувь нь хэнд хамаатай, хамаагүй болохыг хэлж мэдэхгүй байна. (Зураг 3.)

Зураг 3 Сонирхлын зөрчлийн тухай хууль хэнд их хамаатай гэж бодож байна вэ?




Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг МЭДНЭ гэсэн 645 иргэний 63 хувь нь “Албан тушаалтны ашиг сонирхлын мэдүүлэг олон нийтэд нээлттэй байх ёстой” гэж хариулсан. Энэ нь нийт судалгаанд оролцогчдын 19 хувь нь хуулийн 25.1-д “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг нээлттэй байна” гэсэн заалтыг мэдэж байна. (Зураг 4.) Харин нээлттэй байх ёсгүй (23%) гэж үзэж байгаа хүмүүсийн 68 хувь нь “Хувь хүний нууц” гэж үзжээ.

Зураг 4 Албан тушаалтны ашиг сонирхлын мэдүүлэг олон нийтэд нээлттэй байх ёстой юу ?




Төрийн албан хаагч ажлаа хийхдээ төрийн болон нийтийн ашиг сонирхолтой хувийн ашиг сонирхол зөрчилдөж байгаа тухай мэдэгдэх ёстой эсэх, мэдүүлгээ хэд хоногийн дотор гаргаж өгөх ёстойд дээрх хуулийг МЭДНЭ гэж хариулсан иргэдийн 56 хувь нь “Мэдэгдэх ёстой”, 44 хувь нь “30 хоногийн дотор мэдүүлгээ гаргаж өгнө” гэсэн хариултууд өндөр хувь эзэлж байгаа боловч энэ нь нийт судалгаанд оролцогч 1948 иргэний 18 хувь болно. Тиймээс үлдсэн 82 хувь нь үндсэндээ энэ хуулийн талаарх мэдлэг муу байна гэж үзэж болох юм. (Зураг 5-6.)

Зураг 5 АСЗ-ж байгаа тухайгаа мэдэгдэх ёстой юу ?



Зураг 6 АСЗ-ийн мэдүүлгээ хэд хоногийн дотор гаргаж өгөх ёстой вэ ?



Бүс нутгийн хөгжил сайн хууль дүрэмтэй байхаас гадна тухайн газар амьдарч байгаа эгэл жирийн иргэдээс эхсүүлэн улс орныг удирдан чиглүүлж яваа хүмүүсээс хамаардаг. Тэгвэл төсөл хэрэгжих сумдын иргэд орон нутгийн хөгжлийг хэнээс илүү их хамаарна гэж харж байна вэ? (Зураг 7.)

Зураг 7 Сумын хөгжил хэнээс хамгийн их хамаарах вэ?



Нийт судалгаанд оролцогчдын 2 хүн тутмын нэг нь сумын засаг даргаас хамаарна гэж үзэж байна. Үүний дараагаар сумын ИНХ-ын дарга, аймгийн засаг дарга нар орж байна. Иргэн надаас хамаарна гэсэн хариулт МУ-н Ерөнхийлөгч, засгийн газрын гишүүдээс хамаарна гэсэн хариултаас илүү хувийг эзэлж байна. Гэвч иргэн надаас хамаарна (5.3%) гэсэн хариултын хувь бага байгаа нь хөгжлийн бодлого тодорхойлох, шийдвэр гаргалтанд иргэдийн оролцох боломж бага байснаас үүдэн эрх мэдэл төвлөрч байгаа хүнд (засаг дарга) илүү хамааруулан ойлгож байна.

Нэг. Төрийн байгууллагаас мэдээлэл авч байсан туршлага ба мэдээлэл авсан байдал


Иргэд төрийн байгууллагатай мэдээлэл авах, үйлчилгээнд хамрагдах, өргөдөл /гомдол гаргах гэсэн гурван үндсэн хэлбэрээр үйлчлүүлнэ гэж үзсэн.

Сүүлийн нэг жилийн хугацаанд нийт оролцогчдын 15 хувь (296 иргэн) нь мэдээлэл авахаар хүсэлт гаргасан, 21 хувь (403 иргэн) нь үйлчилгээнд хамрагдсан, 10 хувь (185 иргэн) нь өргөдөл, гомдол гаргаж байжээ.

Мэдээлэл авахаар хүсэлт гаргасан (296) иргэдийн 60 хувь нь амаар, 31 хувь нь бичгээр, 6 хувь нь утсаар, 3 хувь нь бусад хэлбэрээр илэрхийлсэн. Харин мэдээлэл авсныхаа төлөө 6 хувь нь 100-45 000 төгрөг, дунджаар 9600 төгрөг төлсөн байна.

Төрийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэд өөрт нь үйлчилсэн төрийн албан хаагчдад “Сайн” гэсэн үнэлгээ өгч байна. (Зураг 8.)

Зураг 8 Танд төрийн албан хаагчид хэр сайн үйлчилсэн бэ?



Иргэдээс төрийн албан хаагчдын маш муугаас, маш сайн гэсэн байдлаар 5 үнэлгээгээр үнэлүүлэхэд 8 хувь нь маш сайн, 42 хувь нь сайнаар, 34 хувь нь дунд зэрэг, 6 хувь нь муу, 5 хувь нь маш муу гэж үнэлсэн. Яг ямар үндэслэлээр “Маш сайн”, “Маш муу” гэсэн үнэлгээ өгч байгааг тодруулахад *хүсэлтийн дагуу бүрэн ойлгомжтой, үнэн зөв мэдээлэл өгч, түргэн шуурхай үйлчилж асуудлыг шийдсэн, дараа хэзээ хаанаас хариугаа авах тухай хэлж өгсөн* тохиолдлыг нэрлэж байсан бол үүний эсрэгээр *мэдээлэл өгдөггүй, өгөхөөс төвөгшөөдөг, дутуу буруу мэдээлэл өгдөг, үл тоож, ялгавартай ханддаг, ажлын цагаар олдохгүй байсан, удаан үйлчилж, хүлээлгэдэг* гэж тайлбарласан.

Жишээ 1. Сүхбаатар аймгийн иргэн - “Тендерийн оролцох материал надад өгөөгүй”
Жишээ 2. Хөвсгөл аймгийн иргэн - “Өөрийн таньдаг хүмүүстээ эхлээд үйлчилдэг.”

Мэдээлэл авахаар хүсэлт гаргасан болон сумын захиргаа, суман дах төрийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн 21 хувьд нь танил талдаа /зуучлагч/ хандсан. Энэхүү иргэдийн дунд танил талгүй бол ажил бүтдэггүй гэсэн яриа байна. (Зураг 9.)

Зураг 9 Яагаад танил тал хэрэгтэй вэ ?




Өргөдөл, гомдол гаргаж байсан иргэдийн (185 иргэн) 37 хувь нь шийдвэрлүүлсэн. Үүний 67 хувь нь 1 сарын дотор, 10 хувь нь 1 сараас дээш хугацаанд шийдвэрлүүлжээ. Өргөдөл гомдлыг нь шийдвэрлэсэн процессын хувьд 36 хувь нь “Шуурхай”, 25 хувь нь “Олон дахин дуудаж чирэгдүүлсэн”, 13 хувь нь “Шийдсэн гэдгээ эргэж мэдэгдээгүй” бол 26 хувь нь энэ асуултанд

хариулаагүй. Сэтгэл ханамжийн хувьд 46 хувь нь ханамжтай байна. Харин шийдвэрлүүлж чадаагүй гэх иргэдийн 51 хувь нь өргөдөл, гомдол гаргаад хагас жил хүртэлх, 29 хувь нь 6 сараас 1 жил хүртэлх, 20 хувь нь 1 жилээс дээш хугацаа өнгөрчээ.

Жишээ 3. ТАХ - ... Иргэд өнөөдөр материалаа өгөөд маргааш авах гэдэг. Гэтэл би тухайн хүний материалыг аваад аймаг руу явуулахад, аймаг хянаад буцаагаад наашаа илгээдэг ...

Жишээ 4. ТАХ- Манайн байгууллагад өнгөрсөн жил нийт 320 өргөдөл, санал ирсэн байдаг үүнээс 2 нь гомдол байсан. Үүнийг нарийн судлаад үзэхэд иргэний өөрийнх буруу болж таарсан. Яагаад вэ гэхээр тухай хүн хуулинд тусгаагүй зүйлийг шаардсан байсан.

Нийт судалгаанд оролцогчдын 59 хувь нь сумын захиргаа болон төрийн байгууллагаар жилд дор хаяж 1-12 удаа, 36 хувь нь хариулаагүй, үлдсэн 4 хувь нь жилд 13 болон түүнээс дээш удаа очдог гэж хариулсан байна.



Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд албан хаагчид ажлын байран дээрээ байдаггүй, олон дахин ирүүлж, чирэгдүүлдэг, хүнд сурталтай байдаг гэсэн шалтгаан гол хүндрэл, бэрхшээл болж байна. (Хүснэгт 2.)

Хүснэгт 2 Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд гарсан хүндрэл, бэрхшээл

Хүндрэл бэрхшээл	Тоо	Хувь
Ажлын цагаар ажлын байран дээрээ байдаггүй	761	19.2%
Олон дахин ирүүлж, хүндрэл чирэгдэл учруулдаг	494	12.5%
Төрийн байгууллагын албан хаагчид хүнд сурталтай байсан	490	12.4%
Төрийн байгууллагын албан хаагчид харилцааны соёлгүй	450	11.4%
Төрийн байгууллагын албан хаагчийн мэдээлэл өгөх байдал хангалтгүй, дутуу байсан	442	11.2%
Хэрэгтэй хэрэггүй нь мэдэгдэхгүй олон бичиг баримт шаарддаг	426	10.7%
Хүндрэл, бэрхшээл гараагүй	421	10.6%
Төрийн байгууллагын албан хаагчид танил тал, шан харамж, хардаг	270	6.8%
Өгч байгаа мэдээлэл, мэдээллийн самбарын мэдээлэл ойлгомжгүй байдаг	189	4.8%
Бусад*	20	0.5%
Нийт	3963	100%

(Бусад* Газрын байцаагч хүнд суртал үзүүлсэн, нарийн мэргэжлийн эмч байхгүй, Өргөдлийн хариу өгөөгүй, үйлчилгээ авахаар очихоор өмнөөс загнадаг, эмнэлэг хүйтэн байдаг.)

Мэдээлэл хүссэн иргэдийн 6 хувь нь төлбөр, хураамж төлж байсан бол нийт судалгаанд оролцогчдын 195 буюу 10 хувь нь төрийн албан хаагч мэдээлэл өгөхдөө мөнгө, шан харамж, бэлэг хүсэх хандлага гаргасан тухай сонсож байсан ба үүний 35 хувь буюу 68 хүн миний таньдаг хүн тэрхүү мөнгө, шан харамж, бэлгийг өгч байсан гэж хариулсан нь хээл, хахууль байдаггүй биш байдаг болж байна. Харин энэ мэт асуудалтай иргэд тулгарвал 3 хүн тутмын нэг нь төрийн албан хаагчаас хүсэх хээл, хахууль, шан харамжийг өгөх хандлагатай байна.

Жишээ 5. Хөвсгөл аймаг Цагааннуур сум ТАХ - Манайх шиг захын сум бол хэцүү аймгаас 10-нд гарсан шуудан 10 хоногийн дараа 20-нд манайд ирдэг. Бид бусдаас хоцорч авдаг.

Жишээ 6. Хөвсгөл аймаг Улаан-Уул сум ТАХ- ТВ-ээр хурал болно гэсэн зар явуулдаг. Иргэд

муухай, сөрөг, сенсацийтай мэдээлэл их сонирхож байна. Гэтэл малын удмын сангийн тухай, тамхины хуулийн тухай ярина гэхээр ирдэггүй.			
Жишээ 7. Сүхбаатар аймаг Асгат сум ТАХ- Засгийн газраас ирж буй албан бичиг хоцорч ирдэг.			
Жишээ 8. Хөвсгөл аймаг Нийгэм халамжийн ажилтан - Самбар дээрх мэдээллийг аваад явдаг. Дээр нь юм бичдэг. Өргөдлийн маягт гэж гаргаад тавихаар мань мэтийг жирэмсэн болгоод биччихсэн байдаг.			
Иргэд төрийн байгууллагаар хэр их үйлчлүүлдэг вэ ?			
63 %	Жилд дор хаяж 1 удаа очиж байна.		
Үйлчлүүлдэг шалтгаан ?			
		Танил тал хэрэгтэй байсан уу? Яагаад?	
15 %	Мэдээлэл авахаар	21% Хэрэгтэй.	Учир нь: Танилгүй бол алгын чинээ
21%	Үйлчилгээнд хамрагдахаар		
10%	Өргөдөл, гомдол гаргахаар	Өргөдөл, гомдол шийдэгдсэн үү ?	
		52 % Үгүй	
		37% Тийм	
		51%	Шийдвэрлээгүй 6 хүртэлх сар болж байна.
		67%	1 сарын дотор
Үйлчлүүлсэн иргэд төрийн албан хаагчдыг хэрхэн үнэлж байна?		Сайн	36% Шуурхай шийдсэн.
Төрийн үйлчилгээний гол асуудал юу байна?		Эзэнгүй ажлын байр	
		Шуурхай бус чирэгдэлтэй үйлчилгээ	
Хээл, хахуул хэр хэмжээнд байна?		10%	Төрийн албан хаагч өөрөө шан харамж, бэлэг хүсэх хандлага гаргаж байсан.
Шан, харамж хүссэн тохиолдод ?		35%	Шан харамж, бэлэг өгсөн.
Иргэд			
Сумын хөгжил хэнээс хамаарах вэ?		51%	Сумын засаг даргаас
		5%	Надаас


Дээрх хүснэгтээс харахад:

- Иргэдийн оролцоо, идэвхи, ухамсар байна уу?
- Эрх мэдэл, шийдвэр гаргалт хэний гарт байна вэ?
- Хээл, хахуулийг хэн өөгшүүлж байна ?
- Төрийн албан хаагчид үнэхээр муу ажиллаж байна уу? гэсэн асуултууд гарч ирж байна. Үүнийг цаашид гарах үр дүнгүүдээр тодруулах болно.

Хоёр. Мэдээлэл авах эрхийн тухай ойлголт


Та төрийн байгууллагаас мэдээлэл авах эрхтэй гэдгээ мэдэх үү гэсэн асуултанд 62 хувь нь “Мэднэ”, 34 хувь нь “Мэдэхгүй” гэж хариулснаас ямар төрлийн мэдээлэл авах эрхтэйг тодруулахад үйл ажиллагаа, төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг авах эрхтэй, мөн нийгмийн халамж үйлчилгээ тэр дундаа мөнгө санхүүтэй холбоотой мэдээлэл хамгийн их ирүүлсэн байна.

Мэдээлэл авах нь ямар хэрэгтэй вэ? гэсэн асуултанд нийт оролцогчдын 40 хувь нь “Мэдээлэлтэй иргэн үйлчилгээ авахад хялбар байдаг”, 36 хувь нь “Ардчилсан нийгмийн иргэн учраас”, 22 хувь нь “Хуульд тусгагдсан байдаг учраас” 2 хувь нь “Бусад” буюу мэдээлэл чухал байна гэсэн шалтгаануудыг хэлсэн.



Тэгвэл “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийг хэр сайн мэдэж байна вэ? Нийт судалгаанд оролцогчдын 9 хувь нь энэ хуулийн талаар Маш сайн, сайн гэж хариулсан бол хариулаагүй иргэдийг нэг талаасаа мэдэхгүй гэж ойлгож болох юм. (Зураг 10.)

Зураг 10 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэр сайн мэдэх вэ?



Аймаг тус бүрээр 1-5 оноогоор үнэлэхэд Баян-Өлгий аймаг хамгийн сайн (3 оноо), Өвөрхангай аймаг хамгийн муу (3.6 оноо) мэдэж байна. Нийт үзүүлэлтээс харахад 3,1 оноотой байгаа ба хуулийн мэдлэгийн тархалж чигд байна. (Зураг 11.)


Зураг 11 Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн мэдлэг аймаг тус бүрээр




Жишээ 9. Засаг дарга – Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг - Естой мэдэхгүй. Батлагдсан хууль байх аа.

Төрийн байгууллагаас тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, худалдан авсан бараа ажил үйлчилгээний тухай, ямар ажлын орон тоо сул байгаа, ямар хүнийг ямар шалгуураар ажилд авсан, орон нутгийн төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг авах эрхтэй гэж нийт оролцогчдын 1/2 нь үзэж байна. Харин хуулинд санхүүгийн асуудлаар шалгагдаж байгаа мэдээллийг авах эрхгүй хэмээн заасан байдаг гэтэл энэхүү мэдээлэлтэй танилцах эрхтэй гэж 30 хувь нь хариулсан нь төрийн байгууллага санхүүгийн мэдээллээ нууж байна гэсэн хардлага иргэдэд төрж болно. Тиймээс хуулийн хориглох заалтын мэдлэг, ойлголтыг иргэдэд өгөх хэрэгтэй. (Зураг 12.)

Зураг 12 Төрийн байгууллагаас дараах мэдээллийг авах эрхтэй юу ?



Зураг 13 Төрийн байгууллагаас мэдээлэл авахтай холбоотой дараах зүйлсд санал нийлж байна уу



Төрийн байгууллагаас мэдээлэл авахдаа шаардлага үндэслэлээ заавал тайлбарлах ёсгүй байдаг. Мөн мэдээллийг ямар хэлбэрээр авахаа иргэн өөрөө сонгох ёстой байдаг. Гэтэл судалгаанд оролцогчдын ихэнхи нь “Мэдээлэл авах болсон үндэслэлээ заавал тайлбарлах ёстой” (49%), “Мэдээллийг ямар хэлбэрээр авахыг сумын захиргаа тогтоож өгөх ёстой” (43%) гэдэгтэй санал нэгдсэн байв. Энэ нь нэг талаас асуултанд автоматаар хариулсан нөгөө талаас иргэдийн энэ талын мэдлэг хангалгүй байгааг харуулж байна. (Зураг 13.)

Иргэдийн мэдээлэл авах эрхтэй гэдгээ мэдэх үү?, төрийн байгууллагаас ямар мэдээллүүдийг авах эрхтэй вэ?, мэдээлэл авахтай холбоотой зүйлсд санал нийлж байна уу?, гэсэн 3 асуултаас харахад иргэдийн мэдээлэл авах эрхийн тухай мэдлэг дундаас дээгүүр харагдаж байна. Үүнийг баталгаажуулж **Мэдээлэл авах эрхээ мэддэг, хуулиа мэддэг** хүмүүс үнэхээр мэдэж байна уу үгүй юу гэдгийг бусад хариулттай харьцуулан харж болох юм.

Судалгаанд оролцогчдын 6,7 хувь (131) нь мэдээлэл авах эрхтэй гэдгээ “Мэднэ”, мөн мэдээлэл авах эрхийн тухай хуулийг “Маш сайн”, “Сайн мэднэ” гэж хариулсан. Эдгээр хүмүүсийн өгсөн хариултыг **“Төрийн байгууллагаас дараах мэдээллийг авах эрхтэй юу?”, “Төрийн байгууллагаас мэдээлэл авахтай холбоотой дараах зүйлстэй санал нийлж байна уу?”** гэсэн асуултын хариулттай харьцуулан нийт судалгаанд оролцсон иргэдийн тоонд эзлэх хувиар илэрхийлбэл дараах байдалтай харагдаж байна. (Хүснэгт 3.)

Хүснэгт 3 Төрийн байгууллагаас дараах мэдээллийг авах эрхтэй юу, мэдээлэл авахтай холбоотой зүйлсд санал нийлж байна уу

Төрийн байгууллагаас дараах мэдээллийг авах эрхтэй юу ?	Тийм	Үгүй	Мэдэхгүй	Төрийн байгууллагаас мэдээлэл авахтай холбоотой дараах зүйлсд санал нийлж байна уу?	Тийм	Үгүй	Мэдэхгүй
Тухайн байгууллагын эзэмшилд байгаа бүх төрлийн мэдээ, баримт бичиг, гэрээ контракттай холбоотой мэдээлэл	3%	2%	1%	Мэдээлэл авахаар хүсэлт гаргахдаа эцэг эхийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газар, цахим шуудангийн хаяг, утасны дугаар, иргэний үнэмлэх зэрэг хувийн мэдээллээ заавал бичиж, тэмдэглүүлэх ёстой	4%	1%	1%
Тухайн байгууллагын эзэмшилд байгаа эд зүйлстэй холбоотой мэдээлэл	2%	2%	1%	Төрийн байгууллагаас мэдээлэл авах болсон шаардлага, үндэслэлээ тайлбарлах ёстой*	4%	1%	1%
Орон нутгийн төсөв санхүүтэй холбоотой мэдээлэл	5%	0	1%	Мэдээллийн агуулгын талаар амаар тайлбарлуулах ёстой	3%	2%	1%
Санхүүгийн асуудлаар шалгагдаж байгаа мэдээлэл *	3%	1%	2%	Мэдээллийн албан ёсны эх сурвалжийг мэдэх ёстой	4%	1%	1%
Ямар хүнийг ямар шалгуураар ажилд авсан тухай мэдээлэл	5%	0	1%	Таны иргэний үнэмлэх, бичиг баримтыг албан тушаалтан таных мөн эсэхийг хянан шалгах ёстой	4%	1%	1%
Ямар ажлын орон тоо сул байгаа талаарх мэдээлэл	5%	1%	1%	Албан тушаалтан танд мэдээлэл өгөхөөс татгалзсан бол шалтгаанаа заавал тайлбарлах ёстой	4%	1%	1%
Төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлэгтэй танилцах	2%	2%	2%	Төрийн байгууллагатай холбоотой мэдээллийг ямар хэлбэрээр (амаар, бичгээр, цахим гэх мэт) авахыг сумын захиргаа тогтоож өгөх ёстой*	3%	1%	1%
Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний талаарх мэдээлэл	3%	1%	1%	Мэдээлэл авах эрхээ зөрчсөн гэж үзвэл эрх бүхий, байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.	4%	1%	1%
Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журмын талаарх мэдээлэл	4%	1%	1%				

*“Үгүй” гэсэн хариулт нь хуулиа мэдэж байгаа гэсэн үг болно.

Мэдээлэл авах эрх, мэдээлэл авах эрхийн тухай хуулиа сайн мэдэж байгаа иргэд (6,7%) “Үгүй”, “Мэдэхгүй”, зарим нэг асуултанд* “Тийм” гэж буруу хариулт өгснөөс үүдэн нийт дүнг 3-4 хувиар буурахад хүргэж байна. Үндсэндээ мэдээлэл авах эрхтэй гэдгээ мэддэг, мэдээлэл авах эрхийн тухай хуулиа сайн мэддэг иргэд нийт судалгаанд оролцогч иргэдийн 3,7-4,7 хувийг эзэлж байгаа юм.


Дээрх үр дүнгээс харахад иргэдийн мэдээлэл авах эрхийн тухай хуулийн мэдлэг хангалтгүй байна.

1. Хуулиар ил тод байх ёстой хэмээн заасан 4 төрлийн мэдээллийг авах эрхтэй гэж нэрлэсэн нэг ч тохиолдол байсангүй.
2. Асуулганд оролцогчдын 22 хувь яагаад мэдээлэл авах эрхтэй гэсэн асуултанд хуульд тусгагдсан байдаг учраас гэж байгаа нь нөгөө талаас хуулиар төрийн байгууллагын бүх мэдээллийг хоригловол үг дуугүй биелүүлэх болж байна.
3. Мэдээлэл авах эрхийн тухай ойлголт өгөхөөс гадна ямар үед, ямар мэдээллүүд хаалттай байх буюу хуулиар хязгаарлсан заалтуудын талаарх мэдээллийг иргэд, төрийн албан хаагчдад өгөх хэрэгтэй байна.
4. Иргэд мэдээлэл авах ЭРХТЭЙ гэдээ мэдэж байгаа боловч “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” ХУУЛИЙН МЭДЛЭГ муу байна.
5. Иргэд энэ хуулиа мэдэхгүй бол төрийн үйл ажиллагааны ил тод байдал хангагдаж, иргэд мэдээлэл авах эрх эдэлж чадах уу ?

Гурав. Ил тод, шударга байдал


Иргэд төрийн байгууллагын мэдээлэл ямар учраас ил тод байх ёстойг “Төрийн байгууллага иргэддээ үйлчлэх ёстой”, “Төрийн байгууллага иргэдийн татварын мөнгөөр санхүүждэг учраас” гэсэн байдлаар тайлбарлаж, мэдээлэл ил тод байхын ач холбогдлыг “Иргэд мэдээлэлтэй болно”, “Төрийн байгууллагын үйлчилгээ сайжирна”, “Авлига, хээл хахууль багасана” гэж харж байна. (Зураг 14-15)

Зураг 14 Төрийн байгууллагын мэдээлэл яагаад ил тод байх ёстой вэ?



Бусад -Ил тод байснаар иргэд мэдээлэлтэй болно, иргэндээ ил тод байх ёстой, бүгд хамаатай.

Зураг 15 Төрийн байгууллагын мэдээлийг ил тод болгосноор ямар ач холбогдолтой вэ?




Бусад - Иргэд тэгш эрхтэй болно, иргэн төр хоёр хамтран ажиллах боломжтой болно.

Асуултанд хариулт өгсөн иргэдийн 77 хувь нь орон нутагт нь нууц мэдээлэл байдаг, байдаггүй тухай тодорхой мэдэхгүй байна. Хуулиар ил тод байна хэмээн заасан мэдээллүүд захиргааны мэдээллийн самбарт байдаг эсэх, тэрхүү мэдээлэл нь цаг тухай бүртээ шинэчлэгддэг эсэхийг тодруулахад “Сумын хийх гэж буй үйл ажиллагаа, төсөл хөтөлбөртэй холбоотой мэдээлэл”, “Төрийн үйлчилгээ авахтай холбоотой бүрдүүлэх материалын жагсаалт”, “Хийж гүйцэтгэсэн ажлын тайлан”, “Иргэдийг хүлээн авах, уулзах цагийн хувиар”, “Албан хаагчийн ёс зүйн дүрэм”-үүдийг “Байдаг” гэж хариулсан иргэд олон байсан. Харин “Сумын захиргаа болон суман дах төрийн байгууллагын хагас, бүтэн жилийн санхүү, аудитын тайлан”, “Төлбөр хураамжтай үйлчилгээний үнэ, хэмжээ”, “Төрийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг хаана, хэрхэн гаргах талаарх мэдээлэл”-д “Байдаггүй” гэсэн хариултыг өгсөн иргэд олон байв. Мөн асуулт тус бүрийн бараг 1/3-г “Мэдэхгүй” гэсэн хариулт эзэлж байна. (Зураг 16.)

Энэхүү хариултын хэн өгч байгааг нарийвчлан ажил эрхлэлтийн байдалтай харьцуулан үзвэл Сурдаг иргэдийн 44 хувь, МАА, газар тариалан дээр ажилладаг иргэдийн 40 хувь, Хувийн компанид ажилладаг иргэдийн 38 хувь нь “Мэдэхгүй” хэмээн хариулсан байгаагаас эдгээр хүмүүст энэ төрлийн сургалт, мэдээ танилгын ажил түлхүү хэрэгцээтэй байгааг харуулж байна. (Зураг 16.)

Жишээ 10. Хөвсгөл ТАНХ - Мэдээллийн самбарт зарлалын чанартай зүйл л гарна уу гэхээс цааших зүйл шинэчлэгддэггүй. 1998 он байх аа нутгийн Төгөл студи гэж ТВ байсан. Жил гаран ажилласан. Техник хэрэгсэл нь гэмтээд буусан. 7 хоногт 1 цаг дизель асааж цацдаг байсан. Тэр үед иргэд их идэвхитэй байсан.


Зураг 16 Танай сумын мэдээллийн самбарт дараах мэдээллүүд байдаг уу? Цаг тухай бүрт нь мэдээлдэг үү?



Удирдах албан тушаалтнууд олгогдсон эрх мэдлийнхээ хүрээнд шийдвэр гаргаж, үйл ажиллагаа явуулсны үндсэн дээр хийсэн ажлаа олон нийтэд тайлагнадаг байх ёстой. Энэ нь нэг талаасаа иргэдэд мэдээлэл болохоос гадна нөгөө талаасаа ажлын үр дүнд хариуцлага хүлээлгэх явдал юм.

Иймээс сумын удирдах албан тушаалтнууд үйл ажиллагаа тайлагнадаг уу?, Цаг тухай бүрт нь тайлагнаж байна уу? Хаана, хэрхэн тайлагнаж байна вэ? гэсэн бүлэг асуулт тавихад иргэд дараах байдлаар хариулсан байна. (Зураг 17.)

Зураг 17 Удирдах албан тушаалтнуудын үйл ажиллагаагаа тайлагнах байдал



Дунджаар иргэдийн 41 хувь дурьдсан удирдах албан тушаалтнууд үйл ажиллагаагаа тайлагнадаг, 22 хувь нь тайлагнадаггүй, 37 хувь нь энэ тухай мэдэхгүй гэж хариулжээ. Тайлагнадаг гэсэн хариулт өгсөн иргэдийн 46 хувь нь Цаг тухай бүртээ, 35 хувь нь Алдаг оног, 6 хувь нь Хэзээ ч цаг тухайдаа тайлагнадаггүй гэж хариулжээ. Иргэд аль ч албан тушаалтны үйл ажиллагааны тайланг ихэвчлэн ямар нэгэн хуралд оролцны үндсэн дээр мэдэх боломжтой болж байна.

Засаг дарга, багийн засаг дарга нар үйл ажиллагааны тайлангаа тавьдаг гэдгийг нийт судалгаанд оролцогчдын 50 хувь нь хүлээн зөвшөөрч байна. Энэхүү хоёр албан тушаалтан үйл ажиллагааны тайлангаа тавьдаг, мөн цаг тухай бүрт нь тайлагнадаг гэсэн хариултыг аймаг тус бүрээр нь харвал Булган, Ховд аймгийн иргэд тайлагнадаг гэдгийг хүлээн зөвшөөрөх байдал хамгийн өндөр хувьтай байна. Харин аль ч аймгийн иргэдийн хувьд удирдлагын тайлагнах байдал цаг тухай бүртээ байж чаддаггүй гэдэг нь харагдаж байна. Булган, Хөвсгөл аймгийн иргэд засаг дарга, мөн Булган аймгийн иргэд багийн засаг дарга тайлангаа цаг тухай бүртээ тавьдаг гэсэн хариулт бусдаасаа өндөр хувьтай байна. (Хүснэгт 3.)


Хүснэгт 4. Сумын засаг дарга, багийн засаг дарга нарын ажлаа тайлагнах байдал

Үйл ажиллагаа тайлагнадаг уу?								
	Сүхбаатар	Өвөрхангай	Булган	Архангай	Ховд	Увс	Хөвсгөл	Баян-Өлгий
Засаг дарга тайлагнадаг	46.50%	55.20%	83.20%	56.40%	64.60%	40.40%	52.50%	43.30%
Багийн дарга тайлагнадаг	52.90%	56.50%	76.90%	57.30%	76.80%	23.60%	47.20%	40.30%
Цаг тухай бүрт нь тайлагнадаг уу?								
	Сүхбаатар	Өвөрхангай	Булган	Архангай	Ховд	Увс	Хөвсгөл	Баян-Өлгий
Засаг дарга тайлагнадаг	39.80%	45.00%	64.40%	36.40%	40.50%	16.40%	57.40%	53.10%
Багийн дарга тайлагнадаг	24.40%	46.80%	57.80%	40.70%	46.50%	18.40%	40.50%	51.20%

Сумын захиргаа, иргэдийн нийтийн хурал, боловсрол, эрүүл мэндийн гэсэн 4 байгууллагын үйл ажиллагаа, харилцааны соёл, хууль, дүрэм журам, иргэдэд үйлчлэх ёстой гэдгээ хэр сайн мэддэгийг 1-5 оноогоор үнэлүүлэхэд (1 бол маш муу, 5 бол маш сайн) ярилцлагын үеэр хамгийн их авлигалд автсан, хүнд сурталтай гэх эмнэлгийн байгууллагаас илүү Сумын захиргаа, сумын ИТХ

муу үзүүлэлттэй гарч байна. Сумын захиргаа, иргэдийн нийтийн хурлын нийт үзүүлэлт адилхан үр дүнтэй гарсан. (Зураг 18.)


Зураг 18 Суман дах байгууллагуудын үнэлэмж



Нийт судалгаанд оролцогчдын 53 хувь нь манай суманд төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм байдаг гэсэн боловч энэ хүмүүсийн 51 хувь нь танилцаж байгаагүй гэж хариулсан нь иргэд ёс зүйн дүрэмд юу тусгагдсан байдаг тухай сайн мэдэхгүй гэсэн үг юм.

Төрийн үйлчилгээний шуурхай байдлыг 1-5 оноогоор үнэлэхэд (1 бол маш шуурхай, 5 бол огт шуурхай биш) Хөдөлмөр эрхлэлт, газрын бүртгэл, жижиг дунд бизнес, архив, мал эмнэлгийн үйлчилгээнүүд дундаас доогуур буюу шуурхай байдал муу байна. Боловсролын үйлчилгээний шуурхай байдлын оноо (2.56) 1 рүү хамгийн их төхөж дээрх сумын байгууллагын үнэлэмжийн үр дүнг баталж байна. (Зураг 19.)

Зураг 19 Үйлчилгээний шуурхай байдал



Багийн иргэдийн нийтийн хурал нээлттэй явагдаж, иргэдийн саналыг авах, шүүмжлэл хэлэх боломж 50-иас дээш хувьтай сайн байхад хуралд оролцсон иргэд өөрсдөө санал бодлоо хэлэх, хурлын шийдвэрийн талаарх мэдээллийг иргэдэд хүрэх тал дээр 50-иас доош хувьтай муу байлаа.

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд нийт оролцогчдын 75 хувь нь оролцож байгаагүй. Энэ талаасаа хурлын нээлттэй байдал, санал, шүүмж авах боломж, мэдээллийг хүлээн авах байдлыг мэдэхгүй гэж хариулахад хүргэж байна. Харин сумын ИНХ-д оролцож байсан (23%) иргэд хуралд санал бодлоо хэлж байсан, хэлсэн санал нь хурлын шийдвэрт тусгагдсан гэсэн хариулт “Үгүй” гэх хариултаас илүү хувьтай байна. (Хүснэгт 5.)

Хүснэгт 5 Багийн ИНХ, сумын ИТХ-ын тухай

Асуулт	Тийм	Үгүй	Мэдэхгүй	Асуулт	Тийм	Үгүй	Мэдэхгүй
Багийн иргэдийн нийтийн хуралд оролцоход нээлттэй байдаг уу?	64%	13%	21%	Сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд оролцоход нээлттэй байдаг уу?	33%	26%	38%
Багийн иргэдийн нийтийн хурлын шийдвэр бүрийн тухай мэдээлэл хүлээн авдаг уу?	46%	50%		Сумын иргэдийн төлөөлөгчдийн шийдвэр бүрийн тухай мэдээллийг хүлээн авдаг уу?	34%	62%	
Багийн иргэдийн нийтийн хурал шийдвэр гаргахдаа иргэдийн саналыг авдаг уу?	54%	16%	29%	Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал шийдвэр гаргахдаа иргэдийн саналыг авдаг уу?	33%	23%	43%
Багийн иргэдийн нийтийн хурал дээр дарамтгүйгээр санал шүүмж хэлж болдог уу?	61%	12%	25%	Сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд дарамтгүйгээр санал шүүмж хэлж болдог уу?	36%	16%	46%
Багийн иргэдийн нийтийн хуралд оролцож байсан уу?	57%	40%		Сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд оролцож байсан уу?	23%	75%	
Багийн иргэдийн нийтийн хуралд санал бодлоо хэлж байсан уу?	27%	28%		Сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд санал бодлоо хэлж байсан уу?	12%	10%	
Хэрэв “Тийм” бол таны санал бодол хурлаас гарсан шийдвэрт тусгагдсан уу ?	12%	9%	4%	Хэрэв “Тийм” бол таны санал бодол хурлаас гарсан шийдвэрт тусгагдаж байсан уу?	5%	4%	2%


Аймаг тус бүрээр харвал багийн ИНХ, сумын ИТХ-ын нээлттэй байдал, түүнд оролцох иргэдийн оролцоогоор Булган аймаг бусад аймгуудаа тэргүүлж байна. (Хүснэгт 6.)

Хүснэгт 6 Багийн ИНХ, сумын ИТХ-ын нээлттэй байдал, иргэдийн оролцоо

	Сүхбаатар	Өвөрхангай	Булган	Архангай	Ховд	Увс	Хөвсгөл	Баян-Өлгий
Багийн хурал нээлттэй байдаг	64.40%	70.20%	85.40%	69.90%	88.40%	43.70%	62.80%	58.80%
Багийн хуралд оролцож байсан	60.50%	56.00%	83.20%	70.60%	61.80%	42.10%	62.50%	54.30%
Сумын ИТХ нээлттэй байдаг	23.00%	27.30%	51.20%	38.10%	39.70%	24.40%	39.40%	41.20%
Сумын ИТХ-д оролцож байсан	16.50%	16.90%	31.10%	22.00%	24.60%	17.10%	29.60%	33.00%

Ямар нэгэн асуудлаар харьцаж хандахад иргэдэд хамгийн ойр, дотно байдаг төрийн албан хаагч нь сургууль, цэцэрлэгийн багш, багийн дарга нар байна. (Зураг 20.)

Зураг 20. Иргэдэд ойр төрийн албан хаагчид (хамгийн ойр байдгаас эхлүүлэн жагсаавал)



Төрийн үйлчилгээ үзүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл

Жишээ 11. Хөвсгөл аймаг ТАХ - Суманд хүнд суртал гэдэг зүйл ер нь бол байхгүй шүү дээ. Аймаг, хотод хүндэрлүүд гардаг. Суман дээр нэг хүн бүх зүйлээ хийж байхад аймаг дээр олон хүн дамжих болдог.

Жишээ 12. Хөвсгөл аймаг ТАХ - Төрийн албан тушаалд очихоороо иргэдээсээ дээр гарчихлаа гэсэн сэтгэхүйтэй болчихдог. Би бол иргэнээсээ дээрх хүн гэсэн байдлаар хүнтэй харьцдаг.

Жишээ 13. Баян-Өлгий аймаг - Хэлний бэрхшээл байна. Яагаад байгаа гэхлээр манай малчид, иргэд бүгд казак хэлтэй монголоор бичиж ойлгох нь муу гэтэл төрийн үйлчилгээ монгол хэлээр явдаг.

Жишээ 14. ТАХ - Хотод хүмүүс их интернэт хэрэглэдгийг бүх улс даяараа хэрэглэж байна гээд аймаг сумын интернэт хэрэглэгчдийн индексийг үл тоомсорлон зарим тогтоол журам ирэхгүй байна

Дээрх үр дүнгээс харахад төрийн байгууллагын мэдээлэл ил тод болсноор авлигал, хээл хахуул багасах боловч иргэдийн мэдээлэл авах эрхийн тухай хуулийн мэдлэг учир дутагдалтайгаас гол саад үүсч байна.

Хуулиар ил тод байна гэж заасан мэдээллүүд самбарт байгааг мэдэж байгаа болон тэрхүү мэдээлэл нь цаг тухай бүртээ мэдээлэгддэг гэх үзүүлэлт байдаггүй, алдаг оног байдаг гэх үзүүлэлтээсээ харьцангуй өндөр хувийг эзэлж байгаа боловч аль аль нь нийт судалгаанд оролцогчдын 50 хувьд хүрч чадахгүй байна.


Иргэд сургуулийн багш А, эмнэлэгийн эмч Б –ийн үйл ажиллагааны тайлангаас илүү тухайн байгууллагын удирдлагын үйл ажиллагааг сонсохыг хүсдэг, сонирхдог. Гэтэл Засаг дарга, багийн дарга нараас бусад удирдлагуудын тайлагнах байдал мөн 50 хувьд хүрэхгүй байна.

Дөрөв. Мэдээллийн эх сурвалж

Судалгаанд оролцосон нийт иргэдийн 33 хувь нь ТВ, 15 хувь нь “Найз нөхөд, танил тал”, 12 хувь нь “Гэр бүл”, 12 хувь нь сонин, 11 хувь нь “Ам дамжсан яриа”, 9 хувь нь гар утас, 6 хувь нь интернэт, 2 хувь нь “Fm, радио”-оос мэдээлэл авдаг.


Харин орон нутгийнхаа тухай мэдээллийг найз нөхөд танил тал, гэр бүлийнхэн, захиргааны албан хаагчид, захиргаан дээрх мэдээллийн самбар, хэвлэмэл материалаас ихэвчлэн авч байна. (Зураг 21.)

Зураг 21 Орон нутгийнхаа тухай мэдээллийг хаанаас авдаг вэ?



Мэдээлэл авах гол хэрэгслүүд болж, хамгийн олон давтагдан нэрлэгдсэн 10 хүртэлх ХМХ-г зураг 22,23-т жагсаан үзүүлсэн. Эндээс харахад төрөл бүрийн мэдээллийг орон даяар цацагддаг телевизүүдээс МҮОНТ, ТВ9, ТВ5, өдөр тутмын сонингоос “Өдрийн сонин”-г, 10 хоног тутмын хэвлэлээс “Хүмүүс”, “Сэрүүлэг”, МҮОНР ашиглан түгээвэл хүртээмж өндөртэй байна. (Зураг 22)

Зураг 22 Төрөл бүрийн мэдээ, мэдээлэл авдаг ХМХ




Жишээ 15. Хөвсгөл аймаг - Айл бүрт хүрэх чанга яригч, радио байсан бол, мэдээлэл түгээхэд зүгээр. Гэхдээ ихэнхи иргэд хөдөө баг дээр амьдардаг.

Жишээ 16. Хөвсгөл аймаг - Гэртээ суугаад ТВ үздэг болчихсон үед гэрт нь л сонгох хэрэгтэй. Дахин дамжуулах сүлжээ бас тавибал зүгээр байна. Манай сумын иргэдийн 70 хувь нь сүлжээгүй газар хөдөө баг дээр амьдарч байна.

Тухайн орон нутагттай холбоотой мэдээллийг МҮОНТ, Өдрийн сонин, МҮОНР болон тухайн орон нутгийн ХМХ-эрэгслээс дамжуулбал илүү үр дүнтэй болно. Тухайлбал Өвөрхангай аймгийн хоёр сумын мэдээллийг Шинэ хар хорин, Хужиртын мэдээ сонин, Өвөрхангай ТВ-ээр, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын мэдээллийг Цуурай ТВ-ээр, Баян-Өлгий аймгийн сумдын мэдээллийг казак хэл дээрх радио нэвтрүүлгээр дамжуулах хэрэгтэй юм. (Зураг 23.)

Зураг 23 Орон нутгийнхаа тухай мэдээлэл авдаг ХМХ



Мэдээ, мэдээлэл авах гол суваг нь дээрх байдалтай байгаа бол гар утас, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ашиглаж, хэрэглэх байдлыг дараах хүснэгтээс харж болно. (Хүснэгт 7.) Нийт асуултанд хариулагчдын 59 хувь гар утсыг, 29 хувь мессеж үйлчилгээг “Байнга” хэрэглэдэг, 42 хувь телевизийг “Ер нь” үздэг, 39 хувь сонинг “Хааяа” уншдаг гэсэн үзүүлэлт хамгийн өндөр хувьтай байна. Харин FM, радио, интернэтийн байгын хэрэглээ 6 хувиас хэтрэхгүй байна.

Хүснэгт 7 Мэдээлэл түгээх хэрэгслийн хэрэглээ


	Гар утас	Мессеж үйлчилгээ	ТВ	Сонин, хэвлэл	FM, радио	Интернэт
Байнга	59.1%	29.2%	36.8%	12.2%	6.3%	6.4%
Ер нь	22.2%	25.2%	41.5%	26.7%	11.7%	10.2%
Хааяа	11%	23.2%	16.4%	39.3%	21.8%	14.8%
Бараг үгүй	3.7%	13.4%	2.6%	15.7%	24.7%	12.8%
Огт үгүй	4%	9.1%	2.6%	6.1%	35.5%	55.8%
Нийт	100%	100%	100%	100%	100%	100%

Төсөл хэрэгжих 20 сумын 10 нь нутгийн радиотой. Энэ 10 сумын радиогийн хэрэглээг нутгийн радиогүй 10 сумтай харьцуулан 1-5 оноогоор үнэлэхэд 0,3 оноогоор нутгийн радиотой сум FM радиог илүү сонсож байна. Гэвч энэ бол тийм хангалттай үр дүн биш юм.

Дээрх мэдээлэл түгээх хэрэгслийг Огт ашиглаж, хэрэглэдэггүй хүмүүсийн хувьд 1/3-ээс илүү хувь нь “Байдаггүй” гэсэн шалгаан хэлэв.

Иргэд орон нутгийнхаа тухай мэдээллийг **захиргааны ажилтнуудаас авдаг** гэж 16 хувь, Хэвлэмэл тараах материал **хүртээмжтэй байдаг** гэж мөн 16 хувь нь хариулсан. Тэгвэл тэдгээр төрийн албан хаагчдын өгч байгаа мэдээлэл, бэлгтэн гаргаж байгаа хэвлэмэл, тараах материалын агуулгын ойлгогдох байдалд иргэд дундаас дээгүүр үнэлгээ өгөв. (Хүснэгт 8.)

Хүснэгт 8 Мэдээллийн ойлгогдох байдал



Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумаас бусад төсөл хэрэгжих суманд сумын вэб сайт гэж тусдаа байдаггүй харин аймгийн сайтанд булан байдлаар орсон нь бий.

Иргэд ямар төрлийн мэдээллийг аль ХМХ-ээр, мэдээлэл түгээх ямар сувгаар авахыг хүсч байгааг тус бүрчлэн асуусан. Хамгийн их санал авсан таван мэдээний төрлийг жагсаахад хууль, эрх зүй, дүрэм, журмын талаарх мэдээллийн хэрэгцээ өндөр байна. Төсөв санхүү, төсөл хөтөлбөрийн мэдээллийг иргэд захиргааны мэдээллийн самбараас, орон нутгийн мэдээллийг захиргааны мэдээллийн самбар, FM, радио, сонин хэвлэлээс, Цаг үеийн мэдээлэл, мэдээ мэдээллийг радиогоос бусад бүх сувгаар, улс төрийн мэдээллийг телевиз, сониноос авч байхыг хүсч байна. (Хүснэгт 9)

Хүснэгт 9 Иргэдийн хүсч буй мэдээллийн төрөл, мэдээлэл түгээх суваг тус бүрээр

Захиргааны мэдээллийн самбараас	Гар утсандаа	Телевизээс	FM, радио	Сонин хэвлэл	Интернэт
Төсөв санхүү	Цаг агаар	Цаг үеийн мэдээлэл	Дуу, хөгжим	Хууль эрх зүй, дүрэм журам шийдвэр	Гадаад мэдээ
Хууль эрх зүй, дүрэм журам шийдвэр	Зурхай	Хууль эрх зүй, дүрэм журам шийдвэр	Зар мэдээ, үнэ ханш	Мэдээ мэдээлэл	Мэдээ мэдээлэл
Төсөл хөтөлбөр	Зар мэдээ, үнэ ханш	Цаг агаар	Орон нутгийн мэдээлэл	Улс төрийн мэдээлэл	Сонин хачин
Орон нутгийн мэдээлэл	Цаг үеийн мэдээлэл	Улс төрийн тухай мэдээлэл	Цаг агаар	Сонин хачин	Хууль эрх зүй, дүрэм журам шийдвэр
Цаг үеийн мэдээлэл	Эрүүл мэндийн талаарх мэдээлэл	Кино, жүжиг	Уран зохиол	Орон нутгийн мэдээлэл, уран зохиол	Танин мэдэхүй
Жишээ 17. Хөвсгөл ТАХ - Гар утсаар – хурлын зарын мэдээлэл, хурлын шийдвэр тогтоол, сануулга мессеж (та татвараа төлсөн үү. та согтуугаар тээврийн хэрэгсэл бариагүй биз.) гэх мэт мэдээлэл түгээх.					
Жишээ 18. Тамгийн газрын дарга – Хүмүүс юу сонирхдог вэ мөнгө л сонирхдог шүү дээ.					

Дүгнэлт

“Иргэдийн мэдээлэл авах эрхийг нэмэгдүүлж, Монголд ил тод байдал шударга ёсыг хөхиүлэн дэмжих нь” төслийн хүрээнд төсөл хэрэгжих 8 аймгийн 20 сумын иргэдийн дунд хийгдсэн суурь судалгааны ерөнхий дүнгээс харахад мэдээлэл авах эрхтэй гэдгээ мэдэж байна. Харин “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийн мэдлэг хангалтгүй байна. Иргэд мэдээлэл авах эрхийн тухай хуулиа мэдэхгүйгээс төрийн байгууллагаас мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, үгээ хэлэх, мэдээлэл авах эрхээ эдэлж чадахгүй байна. Эрх мэдэл төр, түүний байгууллагын удирдлагад төвлөрч байгаагаас иргэдийн идэвхи, оролцоог хаагдаж байна. Мэдээллийн ил тод байдал тодорхой түвшинд хүрээгүйгээс иргэд, төрийн албан хаагчдын дунд үл ойлголцох байдал үүсч төрийн байгууллага, төрийн албан хаагчийн нэр хүнд унах нэгэн шалтгаан болж байна. Мөн төрийн үйлчилгээ авахад чирэгдэл үүсч байна.

1. Иргэд удирдах албан тушаалтнаас гаргаж байгаа шийдвэр, тогтоолыг сонирхож байгаа боловч гарсан шийдвэр, тогтоолын тухай иргэд тухай бүрт нь мэдээлэл авч чадахгүй байна.

Нийт судалгаанд оролцогчдын 39% нь засгийн газрын шийдвэр тогтоолыг, 50% нь засаг даргын шийдвэр, тогтоолыг ИХ сонирхож байхад, иргэдийн 46 хувь нь багийн ИНХ, 34 хувь нь сумын ИТХ-ын шийдвэрийн талаарх мэдээллийг хүлээн авсан байна.

Мөн иргэдэд хэрэгцээтэй байгаа мэдээллийн төрлүүдэд хууль, эрх зүй, дүрэм, журмын талаарх мэдээлэл өндөр үзүүлэлтэй байгаа нь энэ төрлийн мэдээллийн хэрэгцээ байгааг харуулж байна.

2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн мэдлэг хангалтгүй байна.

Энэхүү хуулийг Сайн мэднэ (6%), Ерөнхийд нь мэднэ (27%) гэсэн хүмүүсийн 13% нь хэнд хамаатай хууль болохыг хэлж мэдэхгүй байна. Мөн төрийн албан хаагч ажлаа хийхдээ төрийн болон нийтийн ашиг сонирхолтой хувийн ашиг сонирхолтой зөрчилдөж байгаа тухай мэдэгдэх ёстой (56%), ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгээ 30 хоногийн дотор гаргаж өгөх ёстой (44%) гэсэн хариулт өндөр хувьтай байгаа боловч үлдсэн бараг 50 хувь нь мэдэхгүй эсвэл буруу хариулт хэлж байгаагаас дээрх мэднэ гэсэн 33% бодит байдал дээр буурч байгаа юм.

3. Сумын хөгжил, төрийн байгууллагын үйл ажиллагаа нэг хүн дээр төвлөрч байна..

Сумын хөгжил гэдэг бол цогц, тодорхой хугацаа шаардсан үйл ажиллагаа байдаг. Үүнд тухайн суманд оршин сууж, ажиллаж амьдарч байгаа хүн бүрээс шалтгаалах зүйл. Гэтэл нийт судалгаанд оролцогчдын 5,3 хувь нь сумын хөгжил Надаас хамаарна, 51 хувь нь сумын засаг даргаас хамаарна гэж үзэж байна. Мөн бүлэг хүмүүсээс илүү тодорхой нэг албан тушаалтанд илүү их хамааруулан ойлгох хандлагатай байна.

Аливаа асуудлаар харьцаж, хандахад иргэдэд ойр байдаг төрийн албан хаагчдыг жагсаахад сумын тамгын газрын дарга, иргэдийн хурлын дарга нарын өмнө сумын засаг дарга орж байна. Энэ

үүднээсээ сумын засаг дарга үйл ажиллагаагаа тайлагнадаг гэж нийт судалгаанд оролцогчдын 52 хувь хариулсан бөгөөд энэ үзүүлэлт нь бусад удирдах албан тушаалтнуудаас өндөр хувь эзэлж байв.

4. Иргэдэд мэдээлэл хангалттай хүрэхгүй байх, төрийн үйл ажиллагааны олон шат дамжлага, зохион байгуулалтаас үүдэн төрийн албаны нэр хүнд унаж, танил талаараа мэдээлэл авч байна.

Бид иргэдийг мэдээлэл авах, үйлчилгээнд хамрагдах, өргөдөл/гомдол гаргах гэсэн 3 хэлбэрээр төрийн байгууллагатай харьцана гэж үзсэн. Гэвч иргэдийн ½ нь жилд ядаж нэг удаа төрийн байгууллагаар үйлчлүүлдэг ч дээрх 3 хэлбэрээр харьцсан иргэдийн тоо 21%-иас хэтрэхгүй байна. Хэдийн бага хувь, тоо эзэлж байгаа ч төрийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэд өөрт нь үйлчилсэн төрийн албан хаагчийн үйлчилгээнд сайн үнэлгээ өгсөн. Мөн гаргасан өргөдөл/ гомдлыг 1 сарын дотор шуурхай шийдвэрлэсэн гэсэн үзүүлэлтүүд өндөр хувьтай байна.

Харин үйл ажиллагааны үнэлгээнд бусад байгууллагуудтай харьцуулахад сумын захиргаа хамгийн муу оноо авсан. Учир нь захиргааны мэдээллийн самбарт иргэдтэй уулзах цагийн хуваарь (33%), үйлчилгээ авахтай холбоотой бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт (41%), төлбөр хураамжтай үйлчилгээний үнэ хэмжээ (25%)-ний талаарх мэдээллүүд Байдаг гэсэн үзүүлэлт 50 хувьд хүрэхгүй байна. Үүнээс үүдэн төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд гардаг хүндрэл бэрхшээлийн эхэнд ажлын цагаар ажлын байран дээрээ байдаггүй, олон дахин дуудуулж хүндрэл бэрхшээл учруулдаг гэсэн шалтгаан орж байна.

Төлбөрт үйлчилгээний үнэ, хэмжээний талаарх мэдээлэл хангалтгүй байгаа нь иргэдийн хүссэн мэдээллийг өгөхөд зайлшгүй авах ёстой байсан 100-45 000 төгрөгийг төрийн албан хаагч авсан гэж иргэд ойлгосон байж болно. Үүнийг энэ удаа нарийн тогтоох боломжгүй. Мөн төрийн албан хаагчидтай хийсэн ярилцлагаар бидэнд мэдээлэл цаг тухай бүртээ ирдэггүй, аймаг, хот руу явуулсан бичиг олон хүний гар дамждаг, нэг ажлыг суманд нэг хүн хийж байхад аймаг, хотод олон хүн хийдгээс цаг алддаг зэрэг дээрх бүгд төрийн байгууллагын шат дамжлага, мэдээллийн хүртээмжтэй бус байдал, зохион байгуулалтгүй зэрэг нь танил талаараа зуучлуулахгүй бол ажил бүтэхгүй гэсэн ярианд иргэдийг итгэхэд хүргэж байна.

Ярилцлаганд оролцсон төрийн албан хаагчид ажил үүрэгтэйгээ холбоотой мэдээллээ ихэвчилэн багийн даргаар дамжуулах буюу аман байдлаар олон нийтэд хүргэдэг. Төрийн албан хаагчид өөрсдөө мэдээлэл авахдаа захиргааны болон байгууллагын дотоод хуралд оролцож авч байна.

Ийнхүү багийн даргаар мэдээлэл дамжуулахад хугацаа алдах, буруу зөрүү ойлгогдох, бүрэн мэдээлэгдэхгүй байх учир дутагдалтай байдаг. Харин төрийн албан хаагчдын хувьд төвөөс ирэх мэдээлэл хугацаа алдаж ирдэг, интернэтийн хэрэглээ бага гэсэн ойлголттойгоор орон нутаг руу цахим байдлаар мэдээлэл түгээхэд хайнга хандах зэрэг хүндрэлүүд гардаг байна.

5. Иргэд мэдээлэл авах эрхтэй гэдгээ мэдэж байгаа ч мэдээлэл авах эрхийн тухай хуулийн мэдлэг хангалтгүй байна.

Нийт судалгаанд оролцсон иргэдийн 62% нь мэдээлэл авах эрхтэй гэдгээ, 9 хувь нь мэдээлэл авах эрхийн тухай хуулиа “маш сайн”, “Сайн” мэднэ гэж хариулсан. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулинд 4 төрлийн мэдээллийг ил тод байна гэж заасан байдаг энэ 4

төрлийг авах эрхтэй гэж хариулсан нэг ч иргэн байгаагүй, үүний оронд өөрт хэрэгцээтэй халамж, мөнгө санхүүтэй холбоотой мэдээллийг нэрлэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.” хэмээн заасан.

Мэдээлэл авах эрхтэй гэдгээ мэдэж байгаа болон мэдээлэл авах эрхийн тухай хуулиа мэдэж байгаа иргэдээс олон нийтэд ил тод байх ёстой мэдээллүүдэд авах эрхгүй, авах эрхтэй эсэхээ мэдэхгүй гэсэн хариулт ирүүлсэн. Мөн хуулинд санхүүгийн асуудлаар шалгагдаж байгаа мэдээллийг авах эрхгүй хэмээн заасан байдаг гэтэл энэхүү мэдээлэлтэй танилцах эрхтэй, Мэдээлэл авах хэлбэрээ иргэн өөрөө сонгох эрхтэй байтал сумын захиргаа үүнийг тогтоож өгөх ёстой зэрэг хариултуудыг хэлж байсан. Энэ нь иргэдийн мэднэ гэсэн хариултын бодит байдал болон мэдээлэл авах эрхийн тухай хуулийн мэдлэг муу ямар байгааг хариуулж байгаа юм.

Судалгааны дүнгүүдийг нарийвчлан шүүж үзвэл мэдээлэл авах эрхтэй гэдгээ мэдэж байгаа болон мэдээлэл авах эрхийн тухай хуулийн зүйл заалтаа сайн мэдэж байгаа иргэн нийт судалгаанд оролцогчдын 4%-иас хэтрэхгүй байна. Иргэд мэдээлэлгүй, эрхээ мэдэхгүй нийгмийн хариуцлага суларч, бодлого боловсруулах, шийдвэр гаргалтанд оролцох байдал хумигдаж, сайн засаглалын оролцооны зарчим хэрэгжихгүй билээ.

6. Иргэд мэдээлэлтэй байхын чухал, ач холбогдолтойг ойлгож байгаа ч төрийн байгууллага, төрийн албан хаагчийн олон нийтэд мэдээлэл түгээх байдал хангалтгүй байна.

Судалгаанд оролцогчдын 15%-д төрийн байгууллагын мэдээлэл иргэдэд хэрэгтэй, 16%-д иргэн төрийн хэрэгт оролцох эрхтэй гэсэн ойлголтууд байна. Үлдсэн 69 хувь нь мэдээлэл ил тод байхын учир шалтгааныг төрөөс иргэн рүү чиглэсэн байдлаар харж байна. Харин ил тод байхын ач холбогдолд Иргэд мэдээлэлтэй болно (28%) гэсэн үзүүлэлт хамгийн өндөр хувьтай байлаа.

Иргэд санхүү мөнгөтэй холбоотой мэдээллийг их сонирхдог гэтэл мэдээллийн самбарт сумын захиргаа болон суман дах төрийн байгууллагын хагас, бүтэн жилийн санхүү, аудитын тайлан, төрийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг хаана, хэрхэн гаргах талаарх мэдээлэл самбарт байдаг эсэхийг мэдэж байгаа иргэдийн тоо хангалтгүй байгаа нь иргэдийн дунд төрийн байгууллага, төрийн албан хаагчид төсвийн мөнгө идсэн гэх буруу ойлголт, сөрөг хардлага төрүүлэх суурь болж байна. Мөн иргэд санал гомдлоо хаана гаргахаа мэдэхгүйгээс буруутай албан хаагчдад хариуцлага тооцох боломжгүй болж байна.

7. Шийдвэр гаргах түвшин дэх иргэдийн оролцоо шат ахих тусам буурч мэдээлэл хүртээмжтэй байж чадахгүй байна.

Самбар дээрх мэдээлэл хэнд хүрэхгүй, хэн энэ төрлийн мэдээлэлгүй байна вэ гэвэл сурдаг, МАА, газар тариалан эсвэл хувийн компанид ажилладаг иргэд байна.

Сайн засаглалын бас нэгэн зарчим нь төрийн албан хаагч үйл ажиллагаагаа тайлагнах байдал. Суман дах удирдах албан тушаалтнуудаас сумын засаг дарга болон багийн засаг даргын тайлагнах байдал 50-иас илүү хувьтай байна.

Суманд олон нийтийг хамарсан багийн ИНХ, Сумын ИТХ гэсэн хоёр төрлийн хурал болдог. Энэ хоёр хурлаас харахад багийн ИНХ нээлттэй байдал, санал, шүүмж авах, иргэдийн оролцоо сайн байхад сумын ИТХ-ын талаар иргэд үндсэндээ мэдэхгүй байна. Мөн сумын ИТХ-ын нээлттэй байдал, иргэд санал шүүмж хэлэх, оролцооны идэвхи нь багийн ИНХ-аас харьцангуй муу байна. Энэ нь шат ахих тусам хурлын талаарх мэдээлэл, хурлын шийдвэр, иргэдийн идэвхи, оролцоо багасаж байгааг илтгэнэ.

Багийн иргэдийн нийтийн хурал иргэдийн оролцоотой явагддаг харин хоёр хурлын шийдвэрүүд иргэдэд сайн хүрдэггүй. Учир нь шийдвэр, тогтоолууд хурлын явцад эсвэл дараагийн хуралдааны үеэр л олон нийтэд хүрч байна.

8. Сумын захиргаа, сумын иргэдийн төлөөгчдийн хурал хоёр нэр ондоо болохоос иргэдийн өмнө хүлээсэн үүргээ ялгаагүй муу биелүүлж байна. ИТХ иргэдийн төлөө ажиллаж чадахгүй байна.

Төрийн албан хаагчидтай хийсэн ярилцлагын үеэр “ямар нэгэн төрийн албан тушаалд очихоороо иргэнээс дээр гарлаа гэсэн сэтгэхүйтэй болчихдог, энэ хамгийн хэцүү бэрхшээл” гэж хэлж байсан. ИТХ-ынхан иргэдээс сонгогдож, иргэдийн дуу хоолой болж, төрд хяналт тавих ёстой байгууллага, гэтэл үйл ажиллагаа, харилцааны соёл, хууль, дүрэм, журам болон иргэдэд үйлчлэх ёстой гэдгээ мэдэх байдал гэсэн 4 үзүүлэлтээр хэмжихэд, хяналт тавих гол байгууллага болох сумын захиргаатай адилхан үзүүлэлтэй гарч, бусад төрийн байгууллагаасаа муу үнэлгээ авч байв. Мөн иргэдэд ойр байдаг 10 төрийн албан хаагчдын жагсалтанд иргэдийн хурлын дарга 7-р байранд орж байна. Хөдөлмөр эрхлэлт, газрын бүртгэл, ЖДБ гэсэн эдийн засагтай холбоотой үйлчилгээний шуурхай байдлын үнэлгээ тааруу байгаа нь төрийн байгууллагуудын үйл ажиллагааг муу дүгнэх нэг шалтгаан болно.

Төрийн байгууллагын ил тод, шударга байдал бүрэн хангагдсан гэдгийг 100 хувиар илэрхийлсэн. Үүнд:

- **0%-20%** бол ил тод, шударга байдал огт хангагдаагүй байна.
- **21%-40%** бол ил тод, шударга байдал бүрэн хангагдахад нилээд зүйлсийг хийж, өөрчлөх шаардлагатай байна.
- **41%-60%** бол ил тод, шударга байдал бүрэн хангагдахад зарим нэг зүйлийг зайлшгүй хийх шаардлагатай байна.
- **61%-80%** бол ил тод, шударга байдал бүрэн хангагдахад бага зэрэг зүйлсийг хийх шаардлагатай байна.
- **81%-100%** - ил тод, шударга байдал бүрэн хангагдсан байна.

Төсөл хэрэгжих 8 аймгийн 20 сумын ил тод байдлын түвшин 42%, шударга байдлын түвшин 51% буюу ил тод, шударга байдлын түвшин бүрэн хангагдахад зарим нэг зүйлийг зайлшгүй хийх шаардлагатай гэсэн түвшинд байна.

9. Үзэгч, уншигчдын тоогоор тэргүүлэх ХМХ болон тухайн орон нутгийн мэдээллийн хэрэгсэлийн хэрэглээ сайн байна.

Иргэдийн мэдээлэл авах гол ХМХ-үүд нь орон даяар цацагддаг МҮОНТ, ТВ9, ТВ5 болон орон нутгийн телевизүүд (Өвөрхангайн ТВ, Хөвсгөлийн Цагаан-Уул сумын Цуурай ТВ), найз нөхөд,

танил тал, гэр бүлийн гишүүд байна. Сонин хэвлэлийн тухайд өдөр тутмын сонинуудаас “Өдрийн сонин”, 10 хоног тутмын сонинуудаас “Хүмүүс”, “Сэрүүлэг” болон орон нутгийн “Шинэ хархорин”, “Булганы мэдээ” өндөр хувьтай байв. Баян-Өлгий аймгийн хувьд казак хэлээр нэвтрүүлэг бэлтгэдэг радиогийн суваг мэдээлэл авах нэг гол хэрэгсэл байх боломжтой.

10. Мэдээлэл түгээх шинэ сувгуудын хэрэглээ хязгаарлагдмал байна.

Гар утасны хэрэглээ сайн, гар утсаар мэдээлэл түгээх байдлыг иргэд дэмжиж байна. Гэвч хөдөө багууд дээр гар утсны сүлжээ муу барьдаг, огт байдаггүй гэсэн бэрхшээл бий.

Нийт судалгаанд оролцсон иргэдийн 6 хувь нь интернэтийг байнга, 10 хувь нь ер нь, 15 хувь нь хааяа, 13 хувь нь бараг үгүй, 56 хувь нь огт ашигладаггүй гэж хариулсан. Интернэтийн хэрэглээ орон нутагт муу байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулинд тусгагдсан заалтуудыг иргэд захиргааны мэдээллийн самбараасаа авахыг илүүд үзэж байна. Телевиз, сониноос хууль эрх зүй болоод улс төрийн мэдээллийг, гар утсандаа өдөр тутамдаа хэрэгцээтэй мэдээллүүдийг, FM, радиогоос орон нутаг, чөлөөт цагт зориулсан мэдээлэл, харин интернэтээс гадаад мэдээ, сонин содон мэдээлэл авахыг хүсч байна

Зөвлөмж

Орон нутгийн удирдлагууд, төрийн албан хаагчдад

- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн талаарх мэдлэг олгох, хэрхэн хэрэгжүүлэх тухай сургалтанд хамрагдах.
- Мэдээлэл авах эрхийн тухай хуулиар ил тод байна хэмээн заасан 4 төрлийн мэдээллийг мэдээллийн самбар болон вэб сайтад хүний нүдэнд шууд харагдахуйц байдлаар байршуулан хуульд заасан хугацаанд нь тогтмол шинэчлэх.
- Ил тод байх ёстой мэдээллүүдийг хянах, ерөнхийд нь удирдан чиглүүлэх мэдээлэл, сурталчилгааны ажилтантай болох. Энэхүү ажилтанг ажил үүрэгтэй холбоотой сургалтанд идэвхитэй хамруулдаг байх.
- Сумын иргэдийн гар утасны дугаарыг байнга шинэчилж байх.
- Үндэслэлгүйгээр иргэдээс төлбөр хураамж, бэлэг авсан болон иргэд хүссэн мэдээллээ авч чадахгүйгээс гомдол гаргасны үндсэн дээр буруутай нь тогтоогдсон төрийн албан хаагчдад хариуцлага тооцох механизмыг бий болгох.
- Орон нутгийн төрийн байгууллагын бүх шатны албан хаагчид удирдах байгууллагын өмнө үйл ажиллагаагаа тайлагнахаас гадна иргэдэд тодорхой хугацаанд, хуваарийн дагуу тайлганадаг байх. Энэ тухай журам боловсруулж, нийтэд мэдээлэх.
- Албан хаагчдын ажил үүргийн хуваарь, ёс зүйн дүрмийг мэдээллийн самбар, вэб сайтанд байрлуулах.
- Төрийн албан хаагчдад төрийн үйлчилгээ болон иргэдэд үйлчилэх ёстой гэсэн сэдвээр тогтмол сургалт явуулах, сургалтанд оролцох боломжоор хангаж өгөх.

Орон нутгийн иргэдэд

- Хуулиар хориглосноос бусад бүх мэдээллийг ил байлгахыг төрийн байгууллага, төрийн албан хаагчдаас шаардах, хяналт тавих.
- Төрийн байгууллагатай харьцахдаа мэдээллийн самбар, вэб сайт дээрх мэдээлэлд түшиглэн бүрдүүлэх бичиг баримт, уулзаж хүлээн авах хугацаанд нь ирж гаргасан дүрэм, журмын дагуу үйлчлүүлэх.

- Зарласан хурал, үйл ажиллагаанд идэвхитэй оролцож санал, шүүмжээ хэлдэг байх.

Иргэдийн оролцоог хангах чиглэлээр

- Хуулиар хориглож, хязгаарласан мэдээлэл болон төрийн байгууллагаас хэрхэн мэдээлэл авахтай холбоотой сургалтыг тухайн үед төрөөс үзүүлж байгаа үйлчилгээнд суурилж жилд 2-оос доошгүй удаа явуулах.
- Санал гомдол авах хайрцаг, вэб сайтанд булантай болох.
- Өргөдөл, гомдол бичих загвартай болж, хүлээн авах албан тушаалтныг тодорхой болгох.
- Иргэдийн оролцоог хангах үүднээс иргэдийн санал шүүмж авах, асуудлыг хэлэлцүүлэх талаар хурлын дэгд тодорхой тусгаж, түүнийгээ баримтлах.
- Хурлын шийдвэр тогтоолд санал шүүмж тусгагдсан эсэхэд хяналт тавьдаг байх.

Мэдээлэл хүртээмжтэй байлгах талаар

- Иргэдийг хүлээн авч уулзах, цагийн хуваарь, уулзах ажилтны овог нэр, утасны дугаарыг тодорхой бичиж, байгууллагын мэдээллийн самбар, вэб сайт, тухайн ажилтны өрөөний үүдэнд байршуулах.
- Төрөөс үзүүлэх ямар үйлчилгээг, ямар албан тушаалтан, ямар хугацаанд үзүүлэх, бүрдүүлэх материал зэргийг агуулсан танилцуулгыг үйлчлүүлэгчдэд тараах, энэ тухай мэдээллийн самбар, вэб сайтандаа утгын зөрөөгүйгээр байршуулах
- Бүх шатны хурлын талаарх мэдээллийг сумын хамгийн хол оршин суух иргэн ирэх боломжтой хугацаанаас өмнө хүргэх.
- Төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг мэдээллийн самбар, вэб сайтаар түгээхийн зэрэгцээ хүртээмжтэй байдлаар хэвлэмэл тараах материал, гарын авлага, зурагт хуудас бэлтгэн тараах.
- Төлбөрт үйлчилгээний жагсаалт, төлбөрийн хэмжээг нэг бүрчлэн жагсаан бичиж, мэдээлэл түгээх сувгуудаар цацах.
- Мэдээлэл түгээх суваг болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зөвхөн засаг даргын үйл ажиллагааг мэдээлэхгүй байх. Төрийн үйлчилгээний чиглэлээр орон нутгийн ХМХ-үүдтэй тохиролцон тогтсон хувиартай болж, мэдээллээр хангах.
- Зорилтот бүлэгт чиглэсэн мэдээллийг тэд нарын хүлээн авах хамгийн боломжтой сувгийг сонгон мэдээлэх.
- Мэдээлэл солилцооны үйл ажиллагааг түргэн шуурхай болгох үүднээс мэдээлэл, сурталчилгаа хариуцсан ажилтанд бусад сум, аймаг, хотын мэдээллийн ажилтнуудтай шууд харьцах суваг бий болгож өгөх.
- Бүх шатны хурлаас гарсан шийдвэр, тогтоолыг зөвхөн хурлаар мэдээлэхгүйгээр мэдээлэл түгээх боломжит бүх сувгаар тодорхой хугацааны дотор мэдээлэх.

Төслийн багийнханд

- Төрийн албан хаагчдад “Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Мэдээллийн ил байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” гэсэн хуулийн талаарх сургалт явуулах.
- Авлигал, түүний хэлбэр, таслан зогсоох, бууруулах зэрэг авлигал, хээл хахуультай холбоотой асуудлаар сургалт зохион байгуулах.
- Сайн засаглал, нийгмийн хариуцлага гэж юуг хэлдэг, төрийн байгууллага, төрийн үйлчилгээ, төрийн албан хаагч гэж хэн болох, ямар үүрэгтэй, эрх мэдэл, ажил үүргийн хуваарь гэсэн сэдвээр сургалт зохион байгуулах.
- Мэдээлэл түгээх суваг, ХМХ-үүдтэй хамран ажиллах, мэдээллийн самбар, вэб сайтанд мэдээллийг хэрхэн яаж байршуулах, иргэдийн санал шүүмжийг авч шийдвэрт тусгах талаар арга зүйн туслалцаа үзүүлэх.
- Иргэдэд мониторинг хийх арга зүйд сургаж, дадлага хийлгэх.